

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. "Facebook" компанийн цэвэр ашиг шинжээчдийн таамгийг давж, тус компанийн нэгж хувьцааны ханш өсөн, S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. "General Electric" компанийн хувьцааны ханш мөн адил шалтгаанаар өсч, эрчим хүчний салбарын компаниудын ханшид эерэг нөлөө үзүүлэв. Урт хугацаат бондын өгөөж буурч, банкуудын хувьцааны ханш унажээ.

S&P 500 индексийн сагсыг бүрдүүлж буй компаниудын 117 нь 4-р улирлын санхүүгийн тайлангаа олон нийтэд танилцуулжээ. Даваа гарагт "NVIDIA" болон "Caterpillar" компаниудын хувьцааны ханш буурч, хөрөнгийн зах зээлийн индексүүдэд сөргөөр нөлөөлөв. Энэ долоо хоногт "Facebook" болон "Apple" компанийн хувьцааны ханш өссөн бол "Amazon.com" болон "Microsoft" компаниудын санхүүгийн үзүүлэлтүүд холимог байлаа.

2019 оны 1-р сард ажлын байрны тоо өмнөх сараас 2 дахин өссөн бол хөдөлмөрийн хөлсний хэмжээ тогтвортой байсан талаар АНУ-ын Хөдөлмөрийн яам мэдээлэв. Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл гаргагчдын тоо 2017 оноос хойш хамгийн дээд түвшинд хүрэв. Энэ нь тус улсын Засгийн газрын санхүүжилт зогссонтой холбоотой ажээ.

Лхагва гарагт АНУ-ын Холбооны нөөцийн сан хуралдаж, бодлогын хүүг өөрчлөхгүй байхаар шийдвэрлэв.

Европ: АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан, Европын бүсийн эдийн засгийн удаашрал болоод Итали улсын эдийн засгийн уналт зэргээс үл хамаарч тус бүс нутгийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлт үзүүллээ.

Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй жил гаруй хугацаанд боловсруулсан BREXIT-ийн хэлэлцээрийн төслөө Европын Холбоотой дахин хэлэлцэхээр болжээ. Хэдий тийм боловч Европын Холбоо хэлэлцээрийн төсөлд өөрчлөлт оруулахыг эсэргүүцэж байна. Ингэснээр фүнтийн ханш ам. долларын эсрэг сулрав.

Италийн хөрөнгийн зах зээлийн индекс 1.5%-аар буурч, 2018 оны 2-р хагасаас эхлэн тус улсын эдийн засаг уналтанд оржээ. Италийн ДНБ 0.2 хувиар буурсан нь урьдчилсан таамаг хэмжээнээс өндөр байгаа юм.

Европын холбооны статистикийн хорооны мэдээлснээр 2018 онд Европын бүсийн эдийн засгийн өсөлт сүүлийн 4 жилийн доод түвшинд хүрч, 1.8 хувьтай тэнцжээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс бага хэмжээний өсөлттэй хаагдлаа.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны тодорхой бус байдлаас шалтгаалан Японы ДНБ-ий 17 орчим хувийг бүрдүүлдэг экспортын хэмжээ 2018 оны 12-р сард өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.8%-аар буурчээ. БНХАУ руу экспортолдог аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, электрон бараа бүтээгдэхүүний хэмжээ эрс багассан байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,475.93	0.45% ▲
Dow Jones	АНУ	25,063.89	1.32% ▲
S&P 500	АНУ	2,706.53	1.57% ▲
Nasdaq	АНУ	7,263.87	1.38% ▲
S&P/TSX	Канад	15,506.31	0.91% ▲
FTSE 100	Их Британи	7,020.22	3.10% ▲
S&P/ASX 200	Австрали	5,862.80	-0.72% ▼
Nikkei 225	Япон	20,773.49	0.00% ▲
Hang Seng	Хонг Конг	7,930.74	-71.23% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	110.36
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	98.78
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	98.26
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.62
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.83
DBM' 2023	USD	7.250%	102.00
TDBM' 2020	USD	9.375%	104.70

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.514	0.01 ▲
Libor 3M	2.730	-0.02 ▼
Libor 6M	2.900	0.07 ▲
Libor 1YR	2.960	-0.07 ▼
US 2YR Bond	2.514	-0.09 ▼
US 3YR Bond	2.505	-0.07 ▼
US 5YR Bond	2.517	-0.07 ▼
US 10YR Bond	2.698	-0.05 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.02.02	Өөрчлөлт
USD	2,630.40	-0.09% ▼
CNY	389.99	0.19% ▲
EUR	3,013.52	1.07% ▲
RUB	40.17	0.73% ▲
KRW	2.35	0.00% ▲
JPY	24.02	0.17% ▲
CAD	2,009.17	1.61% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,311.18	0.63% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.78	-0.13% ▼
Зэс	USD/lb.	276.75	1.84% ▲
Нүүрс	USD/MT	97.65	-1.66% ▼
WTI газрын тос	USD/bbl.	55.55	4.10% ▲
Brent газрын тос	USD/bbl.	63.26	3.08% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.70	-7.85% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. XII	8.10%
Бодлогын хүү	2018. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XII	10.80%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XII	12.00%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XII	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XII	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XII	10.50%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 43 компанийн 1,150.1 сая төгрөгийн 3,496,864 ширхэг хувьцаа арилжигдав.


Энэ долоо хоногт “Шивээ овоо” /SHV/ компанийн хувьцаа 14.00%-аар буюу хамгийн ихээр өсч 2,280 төгрөгт хүрч хаагдсан бол “Мерекс” /MRX/ компанийн хувьцаа 25.00%-аар буурч 24 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 8,289 ширхэг үнэт цаас 846.4 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


2-р сарын 02-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,440.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,475.93 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.45%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,153.1
Зах зээлийн үнэлгээ	2,440,931.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,475.93	0.45% ▲
MSE I индекс	9,617.40	-2.66% ▼
MSE II индекс	8,459.23	-2.44% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	9,597,131	697,810,314
АПУ	228,933	138,660,758
Говь	406,682	134,971,183
Таван толгой	19,164	120,920,705
Мандал даатгал	20,103	104,515,055

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Шивээ овоо	2,280.00	14.00% ▲
ЛэндМН ББСБ	74.51	11.38% ▲
Сүү	210.00	4.82% ▲
УБ-БҮК	400.00	3.90% ▲
Говь	338.98	2.56% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Мерекс	24.00	-25.00% ▼
Монгол савхи	480.00	-20.00% ▼
Хөх ган	68.00	-15.00% ▼
Хэрлэн хивс	87.00	-14.03% ▼
Жуулчин дютти фрий	110,000.00	-11.43% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	4,298,496,965
Би Ди Сек	436,726,910
Бумбат-Алтай	224,445,933
Голомт Капитал	164,465,153
Стандарт инвестмент	118,986,337

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	609.86	649,002
Таван толгой	6,170.00	324,944
МИК	14,750.00	305,462
Говь	338.98	264,443
Сүү	210.00	72,240

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	1,404	141,333,660	100,260	101,070	104	14.820%
2	ZGEB-BD-06/16/19-A0254-15.49	3	303,210	101,070	101,070	104	15.490%
3	ZGEB-BD-09/05/19-A0242-15.995	2,804	281,844,060	100,110	100,920	104	15.995%
4	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	807	83,815,020	103,860	103,860	156	15.140%
5	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	100	10,451,000	104,510	104,510	156	15.870%
6	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	889	93,789,500	105,500	105,500	156	16.993%
7	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	906	93,530,910	100,990	105,480	156	16.993%
8	ZGEB-BD-27/03/20-A0225-18	510	54,182,400	106,240	106,240	156	18.000%
9	ZGEB-BD-29/08/19-A0305-14	866	87,158,570	100,240	101,050	104	14.000%

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээсээ давж хаагдлаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК дээр 2019 оны анхны IPO болох “Түмэн шувуут” ХК нь нийт хувьцааны 25% буюу 50,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс өнөөдөр буюу 1 дүгээр сарын 31-ний өдрийн 17:15 цаг хүртэл авч дууслаа.

“Түмэн шувуут” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 2,991 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 54,575,195 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 9.1 хувиар давсан үзүүлэлт боллоо.

“Түмэн шувуут” ХК-ийн үнэт цаас худалдан авах захиалгуудыг хуваарилалтын төлөвлөгөөний дагуу биелүүлж, тайланг 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэх бөгөөд СЗХ-ноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх шийдвэрийг гаргасан үед хөрөнгө оруулагч нар тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх үүсэх юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Давхар бүртгэлтэй үнэт цаасыг хил дамжуулан хөрвүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг СЗХ-нд хүргүүлээ

МХБ-ийн хамгийн анхны давхар бүртгэлтэй компани болох “Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн”-ийн хувьцаа 2018 оны 06 сараас эхлэн Монголын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж байгаа билээ. Тус компанийн хувьцааны 97 хувь нь Торонтогийн бирж дээр, 3 хувь нь МХБ-д тус тус арилжаалагдаж байна. Уг компанийн хувьцаа нь одоогийн байдлаар гадаад, дотоодын захуудын хооронд хөрвөн арилжаалагдахгүй байгаа хэдий ч одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хувьцаа хөрвүүлэх боломжийг нээлттэй болгох боломжтой гэж үзэн, уг чиглэлд хамтран ажиллах саналыг МХБ-ээс СЗХ-нд 1-р сарын 31-ний өдөр хүргүүлээ.

Хувьцааг хил дамнуулан хөрвүүлэх боломжийг нээлттэй болгосноор ханшийн тэнцвэртэй байдлыг хангах, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, зэрэг олон талын ач холбогдолтойгоос гадна стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй бусад компаниудыг давхар бүртгэж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг шинэ шатанд гаргахад чухал ач холбогдолтой билээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

МХБ-д бүртгэлтэй “МИК” ХК-ийн 100 хувийн охин компани “МИК ОССК” олон улсын санхүүгийн зах зээлд 250 сая ам. долларын бонд арилжлаа

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “МИК Холдинг” ХК-ийн 100 хувийн охин компани болох “МИК ОССК” ХХК нь 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр 3 жилийн хугацаатай, жилийн 9.75 хувийн хүүтэй нийт 250 сая ам.долларын үнийн дүн бүхий бондыг олон улсын санхүүгийн зах зээлд амжилттай арилжаалсан байна.

Тус компани нь олон улсын үнэлгээний агентлагуудаас “В” үнэлгээтэй байгаа нь Монгол улсын зээлжих зэрэглэлтэй адил түвшинд байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй компаниуд дотроос хамгийн анхны олон улсын санхүүгийн зах зээлд бонд арилжаалсан компани боллоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 9 хувьтай тэнцлээ

Дотоодын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2018 оны эцэст хоёр их наяд 510 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2.9 хувиар өсөөд байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 9 хувьтай тэнцэх болсныг Санхүүгийн зохицуулах хороо онцоллоо. Үүнд “Топ 20” индекс 2.7 хувиар өссөнөөс гадна дотоодын хөрөнгийн захад олон шинэ бүтээгдэхүүн гарсан нь голлох нөлөө үзүүлжээ.

2017 онд “Топ 20” индекс 70 орчим хувиар өссөнтэй харьцуулахад 2018 онд гол индекс үл ялиг дээшилсэн байна. Харин 2018 онд дөрвөн компани IPO гаргаж, Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг компанийг дотооддоо давхар бүртгэж, нэг компани нэмж хувьцаа гаргасан юм. Эдгээр компаниуд дотоодын хөрөнгийн ухаас нийт 30 гаруй тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээгээр зах зээлийн үнэлгээг өргөжээ. Мөн зах зээлд шинээр гарсан эдгээр зургаан бүтээгдэхүүний дөрвийнх нь ханш 2018 оны эцсийн байдлаар нэрлэсэн үнээсээ өсөөд байсан юм.

2018 онд Монголын Хөрөнгийн бирж нь арилжааны идэвх сул, үүргийн хэрэгжилт хангалтгүй хувьцаат компаниудыг бүртгэлээс хасчээ. 2018 онд хөрөнгийн зах зээлд олон шинэ амжилт тогтоосны нэг нь хувьцааны арилжааны идэвх нэмэгдсэн явдал байлаа. Тоогоор илэрхийлбэл 210 тэрбум төгрөгт хүрч өссөн нь урд өмнө нь байгаагүй өндөр үзүүлэлт болжээ. Энэ нь хувьцааны хөрвөх чадварын үзүүлэлтэд огцом өөрчлөлт авчирсан байна. Өөрөөр хэлбэл 2018 онд хөрвөх чадвар 8.4 хувьд хүрч, 2017 оныхоос 5.2 пунктээр өсчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХААБ 2018 онд 157 арилжаа зохион байгуулж, 711.4 тэрбум төгрөгийн түүхий эд арилжжээ

Хөдөө аж ахуйн бирж 2018 онд нийт 157 арилжаа зохион байгуулж, 711.4 тэрбум төгрөгийн түүхий эд арилжсан байна. Энэ нь өмнөх оноос 20 гаруй хувиар өссөн үзүүлэлт болж байгаа юм.

Мөн нийт арилжааны дүн 700 тэрбум төгрөг давж, бирж байгуулагдсанаас хойших хамгийн өндөр дүнтэй арилжаанд тооцогдож байна. Нийт арилжааны үнийн дүнгийн 83.1 хувийг ямааны ноолуур, 8.4 хувийг завод ноос, 7.9 хувийг хонины ноос бүрдүүлсэн байна. Харин үлдсэн хувийг тэмээний ноос болон бодын хөөврийн арилжаа эзэлжээ. Түүхий эдүүдийн үнэ 2018 онд харгалзан 30-70 хүртэлх хувиар өссөн нь арилжааны дүн нэмэгдэхэд нөлөөлсөн гэж Хөдөө аж ахуйн бирж мэдээлж байсан юм. Өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн барааны үнийн индекс буюу MAPIX индекс 2018 онд 49.8 хувиар өсч, 860 мянган нэгжийг давсан нь түүхий эдүүдийн ханш ямар байгааг илтгэж байна.

2018 оны эцсийн байдлаар нийт 12 брокерын компани хөдөө аж ахуй, түүхий эдийн арилжаанд оролцож байжээ. Цаашид малчид ноолуурын чанартаа илүү анхаарч дотоодын үйлдвэрлэгчдэдээ нийлүүлэх, мөн боловсруулж, нэмүү өртөг шингээж экспортлох шаардлагатай байгааг салбарынхан онцолж байна.

Энэ онд Хөдөө аж ахуйн бирж мал, мах, арьс шир худалдах, худалдан авах талуудын захиалгын дагуу форвард арилжаа зохион байгуулахаар төлөвлөжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Алтны татварын хөнгөлөлт сунгагдаагүй эхний сард алт тушаалт 6 дахин буурав

1-р сарын 29-ний байдлаар Төв банк 183 кг алт худалдаж авсан байна. Энэ нь өмнөх оны 1-р сард худалдаж авсан алтны хэмжээтэй харьцуулахад зургаа дахин бага дүн болж байна.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ 2018 онд багтаан хэлэлцэж, баталж амжаагүйгээс шалтгаалан алтны татвар ес орчим хувь болж өсөх нөхцөл бүрдээд байгаа юм. Үүнээс өмнө татварын хөнгөлөлт 2.5 хувийг таван жилээр сунгахгүй бол Монголбанканд тушаах алтны хэмжээ буурах эрсдэлтэй гэж Төв банк сануулж байв. Монголбанкны Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа "Төв банк алтны татварыг нэмэх нь цаг хугацааны хувьд тохиромжгүй гэж үзэж байна. Сүүлийн 30-аад жилийн алтны тушаалтад дүн шинжилгээ хийгээд үзэхэд татварын хувь хэмжээтэй шууд холбоотой байдаг" гэж мэдэгдэж байсан юм. Учир нь Төв банк гадаад валютын албан нөөцөө зузаатгах төлөвлөгөөтэй байна. 2018 он хувьд алтнаас 700 гаруй сая ам.доллараар валютын нөөцөө зузаатгажээ.

Цаашид дунд хугацаанд гадаад валютын албан нөөцийг 6.5 тэрбум ам.доллар хүргэхээр 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлдээ тусгасан юм. Ирэх жилүүдэд төлөх өр төлбөр, гадаад эдийн засгийн тогтворгүй байдал зэргээс үүдэж валютын нөөцийг нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна. Энэ талаар Олон Улсын Валютын Сан Монгол Улсын гадаад валютын албан нөөцөд эмзэг байдал оршоор байна гэж өмнө нь сануулж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

УУХҮЯ: Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний 39 хоногийн нөөцтэй байна

2019 оны нэгдүгээр сарын 29-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 39 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

ОХУ-аас нийлүүлж буй шатахууны хилийн үнэ төрлөөсөө хамаарч тонн тутамдаа 86-107 ам.доллараар буураад байна. Үүнтэй холбоотойгоор шатахууны жижиглэнгийн үнэ шатахуун түгээх станцуудаар буурах боломжтой болсон гэж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээлэв. Бензиний жижиглэнгийн үнийг төрлөөр ангилбал улсын хэмжээнд А-80 автобензин 76-100 төгрөг, АИ-92 автобензин 89-100 төгрөг, АИ-95 автобензин 70-100 төгрөг, дизелийн түлш 80-100 төгрөгөөр буураад байна. Үүнээс гадна А-80 төрлийн автобензин 97 хоног, АИ-92 автобензин 37 хоног болон дизелийн түлш 35 хоногийн нөөцтэй байна. Мөн ТС-1 маркийн онгоцны түлш 17 хоногийн нөөцтэй байгаа ажээ. 2018 онд Монгол Улс 1.87 сая тонн газрын тосны бүтээгдэхүүнийг дотоод хэрэглээнд импортоор авсныг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Хятадад гангийн түүхий эдийн ханш эрчимтэй нэмэгдэв


Дэлхийн ган үйлдвэрлэлийн гол хэрэглэгч, нийлүүлэгч болсон Хятадад коксжих нүүрс, төмрийн хүдрийн үнэ эрчимтэй нэмэгдэж байна. Өнгөрсөн баасан гаригийн байдлаар Далианы түүхий эдийн бирж дээр нэг тонн төмрийн хүдрийн үнэ сүүлийн 22 сарын хугацаан дахь дээд ханшид хүрч 92.46 ам.доллар буюу 623 юань-тай тэнцжээ. Төмрийн хүдрийн үнэ ийнхүү он гарсаар 20%-иар өсөөд буй юм. Томоохон нийлүүлэгч "Вале" компанийн нийлүүлэлт буурах таамгаас эхтэй уг ханшийн өсөлт нь түр зуурын шинжтэй гэж зарим шинжээч тайлбарлаж байгаа ч ANZ банк энэ онд нийлүүлэлтийн хомсдол үүсч болзошгүй тул үнэ өснө гэж үзжээ.

Коксжих нүүрсний тухайд мөн үнэ өсч эхэлсэн нь хэд хэдэн шалтгаантай. Тухайлбал Хятадын зүүн хойд бүс нутгийн эргийн боомтууд дээр гаалийн хянан шалгалт удааширсны улмаас нүүрс, төмрийн хүдэр ачсан хөлөг онгоцны цуваа үүсчээ. Энэхүү нөхцөл байдал нь нийлүүлэлтэд хүндрэл үүсгэж болзошгүй гэсэн зовнил ган үйлдвэрлэгчдийн дунд төрүүлээд байна.

Мөн АНУ-Хятадын худалдааны дайныг эцэслэхээр хоёр талууд хэлэлцээр хийж буй нь нэлээд ахицтай яваа гэсэн мэдээлэл түгсэн нь цаашид түүхий эдийн эрэлт сайн байх төлөвийг тодруулж байна. Хоёр тал гуравдугаар сарын 1-н гэхэд нэгдсэн ойлголтод хүрч, маргааныг эцэслэх ёстой юм.

Эдгээр мэдээлэл нь Далианы бирж дээр коксжих нүүрсний үнэ сүүлийн 17 сарын хугацаан дахь хамгийн дээд түвшин буюу 1290 юань/тоннд хүрэхэд голлон нөлөөлжээ. Гангийн түүхий эд өсөхийн хэрээр кокс болон арматур төмрийн үнэ ч Хятадын зах зээлд өсч эхэллээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com



БУСАД МЭДЭЭ

2018 онд Монгол улсад 2 тэрбум орчим ам. долларын ГШХО орж иржээ

2018 онд Монгол Улсад хоёр тэрбум орчим ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн гэж Гадаад харилцааны яам мэдээллээ. Үүний 80 хувь нь уул уурхайн салбарт орсон хөрөнгө оруулалт байна.

Харин Төв банк гадаадын шууд хөрөнгө оруулалтын 90 хувь нь мега төсөлд чиглэж байгаа тухай мэдээлсэн юм. Цаашид Засгийн газраас хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэхийн тулд хөдөө аж ахуй, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүчний салбарт түлхүү анхаарч байгаа гэж мэдээллээ. Мөн мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал гэдгийг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Америкийн худалдааны танхимын уулзалтын үеэр илэрхийлж байлаа.

“Оюу Толгой” зэрэг мега төслүүд Монголд орж ирснээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өсгөх ч Засгийн газар үдийн бизнесүүдэд боломж олговол хөрөнгө оруулалт өснө гэж зарим хөрөнгө оруулагчид үзэж байна. Мөн ойрын хугацаанд хөдөө аж ахуй, махны үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт нэмэгдэж магадгүй гэсэн байр суурийг илэрхийлж байлаа. Харин хөрөнгө оруулалтын орчинд тулгардаг гол асуудал нь татвар, хууль эрх зүйн орчин, ил тод байдал гэдгийг дахин нэрлэж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЗГХЭГ: 2018 онд эдийн засаг урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 хувиар өссөн

2018 онд дотоодын эдийн засаг урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 хувиар өссөн гэж ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар мэдээллээ. Үндэсний статистикийн хороо энэ тоог баталгаажуулбал энэ нь сүүлийн дөрвөн жилийн хамгийн өндөр өсөлтөд тооцогдохоор байна.

Эдийн засгийн өсөлтийн албан ёсны дүнг хоёрдугаар сарын дундуур Үндэсний статистикийн хороо зарлах товтой байгаа юм. Мөн Төв банк эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарах төлөв ажиглагдаж байна гэж мэдээллээ.

“Bloomberg TV Mongolia”-ийн дэргэдэх Эдийн засагчдын клубийн шинжээчдийн дийлэнх нь эдийн засгийн өсөлтийг 7.1 хувиас доогуур байх таамаг дэвшүүлсэн юм.

Эдийн засгийн өсөлтийг бүрдүүлэгч хүчин зүйлсийн талаар эдийн засагч Ж.Дэлгэрсайхан “2018 оны өсөлтөд боловсруулах үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар нэг хувиас дээш голлох нөлөөтэй хэвээр байна” гэж мэдээллээ.

2018 оны эхний гурван улирлын байдлаар эдийн засаг 6.4 хувиар өсөөд байгаа юм. Энэхүү өсөлтийн 2.9 пунктыг үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг, 2.5 пунктыг бүтээгдэхүүний цэвэр татвар, 0.7 пунктыг аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг, 0.3 пунктыг хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг бүрдүүлснийг Үндэсний статистикийн хороо мэдээлж байв.

Эх сурвалж: BloombergTv.mn

Хөгжиж буй орнуудын зээлжих зэрэглэл буурч магадгүй байгааг “Fitch” анхааруулав

2019 онд хөгжиж буй орнуудын зээлжих зэрэглэл буурч магадгүй байгааг “Fitch” агентлаг анхаарууллаа. Учир нь гадаад өрийн түвшин өндөртэй хөгжиж буй орнуудад Холбооны Нөөцийн банкны мөнгөний бодлого, ам.долларын ханш чангарч байгаа нь сорилт болохоор байна.

Ялангуяа Латин Америк, Ойрх Дорнод, Африкийн хөгжиж буй орнуудад хамгийн ихээр нөлөөлөхөөр байгааг анхаарууллаа. Эдгээр орны гадаад өр, ялангуяа ам.долларын өрийн хэмжээ өндөр байгаа тул зээлжих зэрэглэлийг бууруулж магадгүй гэж “Fitch” агентлаг үзжээ. Тухайлбал, Засгийн газрын өрийн 83 хувийг нь гадаад өр бүрдүүлж байгаа Аргентин улсын хувьд песогийн ханш өнгөрсөн онд 28 хувиар суларсан нь эдийн засагт нь томоохон сорилт болоод байсан юм. Харин Европын хөгжиж буй орнуудын хувьд зээлжих зэрэглэл өсөх төлөвтэй байгаа бол Азид тогтвортой байхаар байна.

Ам.долларын ханш чангарахад Холбооны Нөөцийн сангийн мөнгөний бодлогоос гадна АНУ-ын эдийн засаг Европ, Япон, БНХАУ-аас илүү хурдацтай өсөхөөр байгаа нь дэмжлэг болох юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

2018 онд банкны зээлийн хүү 2.1 нэгж хувиар буурч, 16.9 хувьд хүрчээ

2018 оны эцэст банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 3.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан үзүүлэлт гэж Санхүүгийн зохицуулах хороо мэдээллээ.

Жилээр нь авч үзвэл хүүгийн түвшин 1.2 нэгжээр буурсан байна. Энэ нь 40 орчим хувийн хүү юм. Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрч өсөхөд актив талаас зээлийн өсөлт бүрдүүлсэн байна. Зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр банк бус санхүүгийн байгууллагуудын харилцагчдын тоо 1.6 сая хүрчээ. Харилцагчдын тоо өсөхөд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрсэнтэй холбоотой юм байна. Нөгөө талаас банкны шаардлага хангахгүй зээлдэгчид банк бус санхүүгийн байгууллагуудад хандах хандлагатай байдаг гэж Санхүүгийн зохицуулах хороо мэдээлж байсан юм.

Тайлант хугацаанд банкуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.9 хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.1 нэгжээр буурсан үзүүлэлт юм. Банкнуудын бизнесийн зээлийн хүүгийн түвшин буурах хандлагатай байгаа аж. Зээлийн өсөлтийг харвал өмнөх оноос 26 хувиар өсч, 17.1 их наяд төгрөг давжээ. Хэдий тийм боловч өнгөрсөн оны зээлийн өсөлтийг иргэдэд олгосон зээл тэргүүлж байна. Иргэдийн зээл 35 хувиар өссөн бол бизнесийн зээл үүнээс хоёр дахин бага буюу 17 хувиар өсчээ. Бизнесийн зээлийг нэмэгдүүлэх зорилгоор Төв банк хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого барьж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.